

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Долларын ханш удахгүй буурна гэв

Монголбанкнаас валютын ханшийн өсөлтийн талаар мэдээлэл хийлээ. Найман шарга дахь валют арилжааны цэгүүдэд өнгөрсөн баасан гарагт ам.долларын ханш 2600 төгрөг давсан юм. Харин арилжааны банкууд иргэдэд ам.доллар худалдахаа зогсоосон байсан. Нэг өдрийн дотор 60-70 төгрөгөөр өссөн ам.долларын ханшийн өсөлтийг Монголбанк түр зуурын үйл явдал гэж тодорхойлсон юм. Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн захирал Б.Лхагважав “Төгрөгийн гадаад валюттай харилцах ханш сүүлийн хоногуудад огцом суураад байна. Үүнийг Монголбанк тэнцвэрт төвшөөсөө хэт хөөрсөн, түр зуурын шинжтэй гэж үзэж байна. Монгол Улсын Засгийн газрын Олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчтай хийх хэлэлцээр үр дүнтэй болж, ойрын хугацаанд санхүүжилтийн асуудал шийдэгдэхээр болсон. Удахгүй буурна. Монголбанкнаас ханшийн энэхүү огцом хэлбэлзлийг тогтворжуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна гэдгийг мэдэгдэж байна” хэмээлээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН: “ЦАЛИНТАЙ ЭЭЖ” ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ 2017 ОНЫ ТӨСӨВТ СУУЛГААГҮЙ

Ж.ОТГОН

УИХ-аар батлагдсан 2017 оны төсөв болон ам.долларын ханшийн өсөлтийн талаар Сангийн сайд Б.Чойжилсүрэн мэдээлэл хийлээ. Сангийн сайд “УИХ-аас эцэслэн баталсан тоогоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг зургаан их наяд 160.2 тэрбум төгрөг байхаар баталсан. 2016 оны тухайд нэгдсэн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл таван их наяд 400 орчим тэрбум төгрөг байгаа. Ирэх жилдээ эдийн засгийн өсөлтийн гурван хувиар нэмэгдүүлээд, нэгдсэн төсвийн орлогыг энэ жилтэй харьцуулахад 700 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Зарлагын хувьд найман их наяд 568.2 тэрбум төгрөгөөр баталсан. Нэгдсэн төсвийн алдагдал 2.5 их наяд байхаар төсвийг баталсан” гэв. Мөн төсвийг батлуулах 2016 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр ДНБ-ий өсөлт 1.3 хувьтай байгаа. Харин 2017 онд энэ тоог гурван хувьд хүргэх бодлого барьж байгаа аж. Ийнхүү гурван хувьд хүргэхийн тулд Засгийн газраас энэ өвөлдөө амжаад хэд хэдэн том төслийг эхлүүлэх бэлтгэл ажлаа эхэлсэн гэнэ. Тухайлбал, Тавантолгой төслийн төмөр замтай хамт Тавантолгойн цахилгаан станц төслийг явуулахад бэлтгэж байгаа аж. Түүнчлэн ТЭЦ-Ш-ийн хүчин чадлыг 250 мвт-аар нэмэгдүүлэх төслийг эрчимжүүлэхээр болоод байгаа юм байна. Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Төсвийн орлогыг сайжруулахын тулд татварын хувь хэмжээнийг нэмэхгүй байгаа. Төсвийн зарлагын тухайд төсвийн бүх байгууллага хэмнэлтийн горимд ажиллахаар өөр аргагүй. УИХ-д өргөн барьсан хуулийн төслөөр төсвийн урсгал зардлыг дахин нэг хувиар бууруулах хууль батлагдсан. Бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн ерөнхий менежердүд тогтоосон орон тоондоо тохируулахад үйл

ажиллагаагаа уян хатан зохицуулах эрхийг өгсөн. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын зээлийн санг үргэлжлүүлэх санхүүжүүлж явахаар болсон. 104.5 тэрбум төгрөгөөр суулгасан. Мөн төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжтэй холбоотой заалтын өмнөх зохицуулалтыг сэргээж 36 сар хүртэл гэж хэвээр үлдээсэн” гэлээ.

Мэдээллийн дараа тэрбээр стегүүчдийн асуултад харуулав.

“Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хэр хэмжээний хөрөнгө шаардлагатай вэ?

“Цалинтай ээж” хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2017 оны төсөвт суулгаагүй. Засгийн газар дээр хэд хэдэн хувилбарар эх үүсвэрийг нь боловсруулаад явж байна. Магадгүй 2017 оны төсөв дээр тодотгол хийвэл энэ хөтөлбөрийн санхүүжилтийн асуудал сөхөгдөх байх.

Валютын ханш хяналтаас гарч, цаг цагаар өсч байна. Засгийн газрын зүгээс Монголбанкнд үүрэг өгөөд биелүүлэхгүй байгаа учраас Сангийн сайдад үүрэг өгсөн гэж ойлгож болох уу?

Засгийн газар Монголбанкнд үүрэг өгдөг эрх байхгүй. Монголбанк УИХ-ын харьяа байгууллага. Тийм учраас Монголбанк Засгийн газар хоёр хамтран ажилладаг. Валютын ханш сүүлийн өдрүүдэд огцом нэмэгдэж байгаа. Үүнийг Засгийн газар анхааралтай ажиглаж, хяналтаа алдахгүй байдлаар явж байгаа. Гол бэрхшээл бол Монгол Улс руу орох валютын урсгал саарсантай холбоотой. Валютын ханш энэ оны төгсгөл, ирэх оны эхээр жаахан буурах байх. Өнгөрсөн жилүүдэд

долоон их наяд 954 орчим тэрбум төгрөгийг зах зээлд хэвлэж хийсэн. Энэ нь валютын эрэлтийг нэмэгдүүлсэн. Энэ эрэлтийг хангахын тулд Монголбанк валютынхаа нөөцийг шавхсан. Шинэ Засгийн газраас валютын урсгалыг дотогш нь болгох асуудлыг гадаадын санхүүгийн байгууллагуудтай яриад явж байгаа. Валютын ханш энэ оны төгсгөл, ирэх оны эхээр жаахан буурах байх. Эцсийн байдлаар шийдвэр гараагүй болохоор одоо хэлэх юм алга. Ойрын хугацаанд эргэж мэдээнэ.

Төсвийн алдагдлыг 2.5 их наяд төгрөгөөр тооцсон байна. Ер нь манай улс хэзээнээс төсвөө алдагдалтай баталдаг болчихсон юм бэ?

Төсвийн алдагдлыг 2.5 их наядаар баталж байгаа нь өндөр хувь мөн. Энэ жил төсвийн хүрээний мэдэгдэл 9.9 хувьд байх ёстой. Ирэх жил долоон хувь, 2019 онд 5.5 хувьд хүргэж 2020 оноос төсвийг алдагдалгүй батлах зорилт тавиад ажиллаж байна. Төсвийн алдагдлыг хэт огцом бууруулбал дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд огцом нөлөөлнө. Тиймээс огцом буулгах бололцоогүй байна. Хэрвээ буулгах юм бол төрийн албан хаагчдын цалин руу орохоос өөр арга байхгүй.

ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах тодотгол хийх үү?

Валютын сангаас манай улс хөтөлбөр авъя гэдгээ илэрхийлсэн. Валютын сангийн төлөөлөгчид Монголд ирээд Монголбанк, Сангийн яамны бүх суурь тоог шалгаж баталгаажуулаад явсан. Манай оронд ирсэн төлөөлөгчид очоод удирдлагуудтайгаа зөвшилцөнө. Бид ч мөн судалгаагаа хийнэ. Хэрвээ өөдрөгөөр төсөөлбөл 2017 оны нэгдүгээр сардаа багтаж валютын сангийн хөтөлбөр манай улсад хэрэгжүүлэх эсэх нь тодорхой болно. Үүний наана хэлэлцээр эцэслэгдвэл тодотгол хийгдэхийг үгүйсгэхгүй. Ингэж байж эдийн

засгийн нөхцөл байдал, бүтцээ өөрчлөхгүй бол манай эдийн засагт хэрэглээ нь давамгайлсан, нэмүү өртөг бүтээх салбартаа харьцангуй сайнгүй байна. Тэгэхээр бүтцийн өөрчлөлтийг хийхээс өөр аргагүй.

Сөрөг хүчний зүгээс төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг 70 тэрбумаар нэмэгдүүлсэн гэж мэдээлж байгаа. 70 тэрбумын нэмэгдлийн талаар тайлбар өгөөч?

АН-ын гишүүд жаахан харууцлаагүй шүүмжлэлийг хийсэн. Өнгөн талаасаа бол тэгж харагдана. 2016 оны зээлийн хүүгийн төлбөрт нэг их наяд 41 тэрбум төгрөгийн зарж байгаа. Гэтэл энэ зээлийн хүүгийн дарамт ирэх жилүүдэд дахиад томроод явна. 2017 оны төсөв дээр нэг их наяд 380 тэрбум орчим төгрөг байхаар хүүгийн зардлыг тусгасан. УИХ дээр тогтворжуулалтын санг ашиглахаас шалтгаалаад зээлийн хүүгийн зардал 40 тэрбумаар бууж байгаа. Өрийн үйлчилгээ болон зээлийн хүүгийн зардал 300 тэрбум төгрөгөөр нэмэгдчихээр бид төсөвт байгууллага дахь бусад зардлыг 120 тэрбум төгрөгөөр буулгах шаардлага гарч байгаа юм. Урсгал зардал дотор зээлийн хүүгийн төлбөр багатай байгаа юм. Бодит гарц бол Монгол Улс руу орох валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ хөтөлбөрийн хүрээнд Хөрөнгийн зах зээлд бонд босгох ажлыг эхлүүлээд байна. Хэлэлцээр ид дундаа явж байна. Энэ сардаа юм уу, ирэх сардаа асуудал тодорхой болох байх. Урд хөршөөс хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх гэсэн асуудлыг тавьсан. Энэ сарын 29-нд эхний уулзалтыг БНХАУ-ын талтай хийнэ. Энэ хүрээнд хамтран ажиллах зөвлөл байгуулагдсан. Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсгийг мөн байгуулсан. Хятадын цагаан сар нэгдүгээр сарын 28-нд юм байна. Цагаан сараас өмнө амжилт хэд хэдэн зоригтой шийдвэрийг гаргах шаардлагатай.

Төсвийн алдагдлыг 9.9 хувиар оруулж ирээд 9.1 хувиар баталлаа. Орлого нэмсэн үү эсвэл зарлагаа хасав уу?

Орлого нэмсэн. Засгийн газраас Тогтворжуулалтын санг 2017 онд ашиглана гэж төсвийн төсөл дээр оруулж ирээгүй. УИХ дээр Тогтворжуулалтын сангийн 300 орчим тэрбум төгрөгийг эх үүсвэр талдаа ашигла гэсэн. Мөн өмч хувьчлалын орлогыг 50 тэрбумаар нэмэгдүүлэхээр болсон. “Монгол шуудан” компанийн

20 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт-Өөрчлөхгүй бол манай эдийн засагт хэрэглээ нь давамгайлсан, нэмүү өртөг бүтээх салбартаа харьцангуй сайнгүй байна. Тэгэхээр бүтцийн өөрчлөлтийг хийхээс өөр аргагүй.

ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдахаас гадна бусад улс орноос зээл авахаар ярьж байгаа. Зээлийн эх үүсвэрийг юунд зарцуулах вэ?

ОУВС-тай хэлэлцээр хийж байгаагийн зэрэгцээ ОХУ, БНХАУ, АНУ, Япон зэрэг том эдийн засагтай орнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэсэн хүсэлтээ тавьж байна. Хугацааны хувьд 20 жилээс доошгүй, хоёр хувийн хүүтэйгээр дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Зээлийн хэмжээний хувьд тохироо эцэслэн хийгдээгүй. Хэрэв зээл авсан тохиолдолд зээлээ дахин санхүүжүүлнэ. Тодруулбал, манай авсан зээлүүд жилийн 10.8 хувийн хүүтэй. Тиймээс тэр өндөр хүүтэй зээлээ бага хүүтэй зээлээр солихгүй бол зээлийн хүүгийн дарамтад орно. Бодлогын төвшинд өөрчлөлт оруулж чадахгүй бол 2017 онд 1.3 их наяд төгрөгийг, 2018 онд энэ тоо хоёр их наяд руу орж ирнэ. Гарцаагүй байдлаас нийм зохицуулалт хийхээр болоод байна.

УИХ-аар төсөв батлахдаа Засгийн газрын өрийг хэдий хэмжээгээр нэмэгдүүлэх эрх олгосон бэ?

Ирэх жил 2.5 орчим их наяд төгрөгийн үнэт цаас шинээр гарах эрхийг УИХ-аас Засгийн газар авсан.

Ирэх оны төсөвт ам.долларыг хэдэн төгрөгөөр тусгасан бэ?

Засгийн газраас төсвийн төслийг боловсруулахдаа 2016 оны есдүгээр сарын 30-ны ханшаар бодож тооцсон. УИХ-аар төсөв батлагдахдаа тэр өдрийн ханшаар тооцож батлах ёстой. Ойролцоогоор нэг ам.долларыг 2400 орчим төгрөгөөр тооцож баталсан.

Өмч хувьчлалын хүрээнд ямар, ямар объектийг хувьчлах вэ?

Төрийн өмчийн компанийг хувьчлаад Засгийн газарт ногдох хувь нь “Төрийн банк” 75 тэрбум төгрөг, Хөрөнгийн бирж 20 тэрбум, “Оргил” рашаан сувилал долоон тэрбум, “Монголын цахилгаан холбоо” компанийн 7.6 тэрбум төгрөгөөр хувьчлана гэж Засгийн газраас төсвийн төсөлд суулгасан. Төсөв батлагдах үед дээрх объектууд дээр хоёр объект нэмж, 50 тэрбумаар нэмэгдүүлэхээр болсон.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

С.ЧИНЗОРИГ: ЭХЧҮҮД, МАЛЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА

Ж.МЯГМАР

УИХ-ын чуулганы баасан гарагийн нэгдсэн хуралдаан эхэлж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж, анхны хэлэлцүүлгээр дэмжигдээд байгаа. Үүнтэй холбоотойгоор хууль санаачилсан УИХ-ын гишүүн С.Чинзориг илтгэл тавьсан юм. Тэрбээр “Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 10 гаруй хувийг үйлдвэрлэдэг мал аж ахуйн салбарт 300 гаруй мянган малчин ажиллаж, тэвээр, худалдаа, үйлчилгээ зэрэг томоохон салбаруудад 240.0 гаруй мянган иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь нийт ажиллагсдын 47.5 хувь болж буй юм. Өнөөдөр малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулах ёстой ч эрхэлж буй үйл ажиллагааны орлого бага, тогтвортой биш, улирлын чанартай зэргээс шалтгаалан хамрагдалтын хувь нэн доогуур байдаг. Үндэсний статистикийн хороо болон нийгмийн даатгалын байгууллагын тоон мэдээгээр малчдын 10 орчим,



хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 15 орчим хувь нь нийгмийн даатгалд хамрагдаж, шимтгэл төлж буйг харж болно. Энэ байдал цаашид удаан үргэлжилбэл малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгаа алдагдахаас гадна Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагчдын тоо мэдэгдэхүйц өсч төсөвт ачаалал үүсгэх сөрөг үр дагавартай юм. Тиймээс Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлж байгаа эдгээр салбар ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах талаар дорвитой арга хэмжээ авах шаардлагатай харгалзан Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээнээс тооцон нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг УИХ-ын нэр бүхий гишүүд санаачлан боловсруулаа. Энэхүү хуулийн төсөл нь Монгол ардын намын УИХ-ын 2016 оны сонгуульд дэвшүүлсэн Мөрийн хөтөлбөрийн 2.9.7, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Малчид, хувиараа аж ахуй эрхлэгчдэд нийгмийн даатгалын шимтгэлээ нэг удаа нөхөн төлөх эрх зүйн орчин бий болгоно” гэсэн заалттай бүрэн нийцэж байгаа болно. Уг хуулийн төслийг батлан хэрэгжүүлсэн тохиолдолд уг хуулийн үйлчлэлд 491.6 мянган хүн хамрагдана. Хэрвээ энэ хуульд малчид, хувиараа

хөдөлмөр эрхлэгчдийн 30-аас дээш насныхан бүрэн хамрагдвал 288.2 тэрбум, 35-аас дээш насныхан бүрэн хамрагдвал 189.0 тэрбум төгрөгийн орлого тэтгэврийн даатгалын санд төвлөрнө гэж тооцож байна. Харин Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-ноос доошгүй жил төлсөн эмэгтэй 55 нас хүрээд, хэрэв дөрвөөс олон хүүхэдтэй бол 50 нас хүрээд өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй. Статистик тоо баримтаас үзвэл жилд 80 орчим мянган эх хүүхэд төрүүлж, 90 гаруй мянган ээж хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлэхгүй байна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн авч буй тэтгэвэр ижил цалин хөлснөөс ердийн нөхцөлөөр тогтоолгосон эхчүүдийнхээс 10-15 хувиар доогуур байдаг.

Эхчүүдийн тэтгэврийн хэмжээ харьцангуй доогуур байгаа нь тэд таван насаар эрт тэтгэвэрт гардаг болон хүүхдээ гурван нас хүртэл асрахаар авсан чөлөөний хугацааны нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөөгүй, эсхүл дутуу төлөгдсөнөөс ажилласан буюу шимтгэл төлсөн хугацаа нь бага байдагтай холбоотой байна. Түүнчлэн тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний

болон амаржсаны тэтгэмжийн нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан эхэд цалин хөлсний дунджаас 100 хувиар, сайн дураар даатгуулсан эхэд 70 хувиар тооцон олгодог нь ижил шалтгаанаар орлогоо адсан тохиолдолд сайн дураараа даатгуулсан эхчүүд бага тэтгэмж авч эрх ашиг нь зөрчигдөж буй юм. Тиймээс эхчүүдийн хүүхэд төрүүлж өсгөсөн хөдөлмөрийг бодитой үнэлж нийгмийн баталгаа нь сайжруулах зорилгоор хүүхэд асарсан хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тасалдуулахгүй төлөх, шимтгэл төлсөн нийт хугацаанд дээр төрүүлж өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор 1.5 жил нэмж тооцох, эхчүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран адил хувь хэмжээгээр жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгох, түүнчлэн малчдын тэтгэвэр гарах насныг таван жилээр наашлуулах боломж бүрдэх юм. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд эхчүүд, малчдын нийгмийн баталгааг хангах, малчдын нийгмийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлнө гэж үзэж байна” гэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Гэвч тэр чухал заалтыг авч хаяад, сонгууль болохын өмнөхөн л баахан өөрчлөлт хийх боломжтой болгосон. Тиймдээч 2016 оны сонгууль болох цаг хаяанд тулчихаад байхад парламент сонгуулийн хууль хэлэлцэж, элдэв өөрчлөлт хийж суусан цаг саяхан. Өмнө нь, 2012 оны сонгууль холимог системээр явж, намын жагсаалтаас баахан хөгшчүүл сонгогдож байлаа. Харин 2016 онд жижиг мажоратори системээр явуулсан. Гэхдээ хамгийн

...Гэтэл сонгууль өгөөгүйнхээ төлөө оркоороо дуудуулаад л байж байна. Энэ асуудлыг дараагийн сонгуулийн өмнө цэгцлээсэй билээ, эрх баригчид. Энэ олон сонгуулиа нэг дор л хийчихмээр байна. УИХ, нийслэл, сум, дүүргийн сонгуулийг нэг дор хийхэд иргэд нэг их толгой нь эргээд, хүнийхээ нэрийг дугуйлахдаа будилахгүй л байх. 10 хүний нэр дугуйлах байсан ч учрыг нь олоод л тойруулчихна...

төгрөг зарцуулсан. Хэрвээ УИХ-ын сонгуультай нэгтгэсэн бол ядаж л тал нь хэмнэгдэнэ. Хэмнэсэн 6-7 тэрбум төгрөгөөрөө цэцэрлэг барьсан бол цөөнгүй асуудлыг шийдэж болохоор л байсан. Гэх мэтээр давуу талыг нь тооцвол барагдахгүй их. Гэтэл одоо болтол бид сонгуулийн үр дүнтэй зууралдаж, зарим нэг газар маргаан, тэмцэл өрнөсөөр л. Ингэж байтал 2017 он гарлаа. Он гарахтай зэрэгцээд Ерөнхийлөгчийн сонгуулийн асуудал босч ирнэ. Бүр одооноос л зарим нэг нам дотор Ерөнхийлөгчийн сонгуулийн төлөөх тэмцэл өрнөөд эхэлчихээд байна. Монголчууд бид жинхэнэ утгаараа сонгуульд дарлуулж гүйцтээ. Сүүлдээ иргэдийн итгэл алдарч, сонгууль өгөөхөөсө хүртэл цааргалж байгаа. Гэтэл сонгууль өгөөгүйнхээ төлөө оркоороо дуудуулаад л байж байна. Энэ асуудлыг дараагийн сонгуулийн өмнө цэгцлээсэй билээ, эрх баригчид. Энэ олон сонгуулиа нэг дор л хийчихмээр байна. УИХ, нийслэл, сум, дүүргийн сонгуулийг нэг дор хийхэд иргэд нэг их толгой нь эргээд, хүнийхээ нэрийг дугуйлахдаа будилахгүй л байх. 10 хүний нэр дугуйлах байсан ч учрыг нь олоод л тойруулчихна. Ингэж зардал мөнгө, цаг заваа хэмнэж, улсын ажлыг урагшуулдаг болмоор байна.

Тэгэхгүй одоогийнх шиг байвал тэгээд л сөнөлөө гэсэн үг. Ядаж байхад манайд төрийн залгамж чанар гэж байх биш. Нэг дарга гарч ирээд, өмнөхийнхөө хийсэн болгоныг сайн, муу, зөв, буруугаар ялгахгүй үгүйсгээд, цоо шинийг сэдээд явчихдаг хойно. Хэрвээ төр нь залгамж чанартай, төрийн албан хаагчид нь халагдах айдасгүй байж, улсын ажил ямар ч үед урагшилдаг бол хэдэн сонгууль хийсэн ч яах вэ. Тийм соёл тогтоогүй, тогттол ч өдий учраас нэг сонгуультай больё. Ерөнхийлөгчийн сонгууль ч гэж хийгээд яадаг юм. Парламент нь сонгогдсонхуоо дараа бэлгэдлийн шинж чанартай нэг хүн томилоод л гүйцээ шүү дээ. Ядуу улс байж их ямбаар яахав. Хөнгөлийнхөө хэрээр л хөлөө жийцгээе зүгээр.

Дугаарын 60 мөр

Д.Трампын ялалт МОНГОЛЧУУДАД ХАЛТАЙ ЮУ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хэзээний дайнч гэдгээрээ зартай БНН найман жилийн дараа төрийн эрхийг эргүүлэн авсан энэ үйл явдал дэлхийн улс орнуудад хэрхэн нөлөөлөх нь эдүгээ таамаг төдий. Гэсэн хэдий ч, олон улс судлаачид Трампын ялалт монголчуудад хэрхэн нөлөөлөхийг дор бүрнээ таамаглахыг оролдож байна. АНУ найтаахад, дэлхий ханиад хүрдэг гэх үг бий. Тэгвэл Трамп сонгуульд ялмагц зах зээлд хүчтэй савалгаа үүсч эхэлсэн. Улмаар ээс, алт, төмрийн үнэ огцом өсч, нэг тонн зэсийн үнэ дунджаар 600 ам.доллароор нэмэгдэж, 5900 болов. Энэ нь сүүлийн 17 сарын хугацаа дахь хамгийн дээд үнэ байлаа. Шинжээчдийн таамаглаж буйгаар АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трампын баримтлах бодлого болон шинэ Засгийн газрын хэрэгжүүлэх мега төслүүдэд их хэмжээний ээс шаардлагатай аж. Тиймээс цаашдаа урт хугацаанд зэсийн үнийн өсөлт үргэлжлэх төлөвтэй байна. Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний үнэ өссөн нь монголчуудын хувьд сайн мэдээ байх нь мэдээж. Ерөнхийдөө дэлхийн хүчирхэг гүрний шинэхэн төрийн тэргүүний хэрэгжүүлэх бодлого Монголд нөлөөлөх нь гарцаагүй. Гэхдээ шууд нөлөөлөхүйц бодлого нь цагаачлалын талаархи амлалт нь юм. Тэрбээр хууль бус цагаачдын эсрэг хатуу бодлого баримтлахаа мөрийн хөтөлбөрийнхөө гол заалт болгож байсан учир Трампын ялалт эрх чөлөөний оронд “харласан” монголчуудад халтай байхыг үгүйсгэхгүй. Түүний хувьд сонгуульд өрсөлдөнө гэдгээ мэдэгдсэнээс хойш мексикчүүдийг зүй бус үгээр доромжилж, АНУ, Мексикийн хилд хана босгоно, мусальман шашинтнуудыг нэгдсэн улсын хилийг нэвтрүүлэхгүй, Япон, БНСУ АНУ-аас тусламж авсныхаа төлөө төлбөр төлөх ёстой, хууль бус цагаачдыг албадан гаргана гэх зэрэг амлалтуудыг өгч байсан билээ. Трампын хэлснээр 11 сая цагаач, тус улсаас хөөгдөх бөгөөд АНУ-д мөндэлсэн хүүхэд тус улсын иргэн болдог хуулийн заалт хүчингүй болж мэднэ. Ингэснээр монголчуудын “нөгөө” мөрөөдөл талаар болно гэсэн үг. Тиймээс эл амлалтаа биелүүлэхийг оролдож, цагаачдын эсрэг хатуу бодлого явуулж эхэлбэл, харласан монголчууд нутаг буцах, эсвэл цагаачлалд ээлтэй муж руу дүрвэн суурьших сонголттой тулгарч болох юм. Трамп Монголын талаар төдийлөн мэдээлэлгүй гэдгээ өмнө нь батлан харуулж байсан удаатай. Мексик АНУ-ын хилд хана босгоно гэх хачин амлалтынхаа талаар нэгэн нэвтрүүлэгт оролдон тайлбарлах үедээ Хятадын цагаан хэрэмийг монголын цагаачдыг хил нэвтрүүлэхгүйн тулд барьсан мэтээр тайлбарлаж, түүхчдийн эсэргүүцэлтэй тулгарч байв. Үүгээр зогсохгүй, биднийг “Азийн мексикүүд” гэж цоллож байлаа. Эдүгээ АНУ-ын конгрессын дээд, доод танхимд БНН дангаар ноёрхож буй. Энэ утгаараа Трампын бодлого хэрэгжих магадлал өндөр гэж харж болох ч, нөгөө талаар, бодит ажил болтол нэлээд хугацааг зарцуулна. Учир нь бизнесмэн эрийг төдийлөн дэмждэггүй бүгд найрамдахчууд ч нэлээд бий. Тэд тийм амархан хөдлөхгүй. Түүнчлэн, мужууд өөрсдөө хуулиа тогтоодог. Иймээс Трампын амлалт тийм амархан хэрэгжиж чадахгүй байх вий. Ямартай ч, Трампын амлалт, бодлого хэрхэн, хаашаа эргэхийг хүлээх л үлдэж байна.

СОНГУУЛИАР АМЬСГАЛУУЛАХ ХУУЛЬ ГАРГАСАН НӨХДИЙГ “ДҮҮЖИЛЬЕ”

гол нь УИХ-ын болоод орон нутгийн сонгуулийг тусад нь явуулахаар болсон нь жинхэнэ утгаараа гай боллоо. Ерөөс 2016 оны турш монголчууд сонгуульдаа байгаад л таарлаа. Худал хэлсэн хүнд одоог хүртэл монголчууд сонгуулийн темпнээсээ гараагүй, улс орны ажил жигдрээгүй байна. Ер нь УИХ, нийслэл, орон нутгийн сонгуулийг нэг дор явуулчихаад яах вэ дээ. Манай эрхэм улстөрчид ард түмнээ тэнэг, юм ойлгодоггүй, гурав, дөрөвхөн хүний нэр дугуйлчих чадваргүй гэж бодож, доромжилж, тус тусад нь хийж байгаа юм уу даа. Гэтэл УИХ, нийслэл, аймгуудын сонгууль гэж энэ оны нэгдүгээр сараас эхлээд л монголчууд талцаж эхэлсэн. Улмаар долдугаар сар хүртэл янз бүр болж явсаар, арай гэж нэг юм сонгууль дуусч байгаа юм. Гэтэл орон нутгийн сонгууль нь 10 дугаар сард болсон. Тэр болтол УИХ, нийслэлийнхэн, цаашлаад аймгийн Засаг дарга нар юу хийв. Юу ч хийсэнгүй. Суманд, дүүрэгт, хороонд ямар намын, хэн ялахыг үндсэндээ хүлээгээд л хэвтчихсэн. Тэр хооронд хаа сайгүй л халаа сэлгээ, томилгоо. Тэрний

дүү нь тийм албанд очлоо, хамаатнаа тэгж дарга болголоо гээд л. Дээрээс нь нийслэлээс авахуулаад яам, тамгын газрын дарга нар нь өрөөгөө гоёж, чимэглээд л. УИХ-ын гишүүд ч ажлаа хийгээгүй. Бүр орон нутгийн сонгуулийн өмнө УИХ-ын уулганаа завсарлуулаад, хөдөө орон нутагт ажиллаж ч байх шиг. Тэгж тэгж нэг юм орон нутгийн сонгууль болж дууслаа. Тэглээ гээд одоо улс орны ажил жигдрээд, сайхан болчихсон юм алга. Сум, дүүрэгт бас л баахан халаа сэлгээ, томилгоо. Өнөөдөр аймаг, сумдын өвлөхжилтийн бэлтгэл ч гүйцэд хангагдаагүй байна. Гэтэл сүүлийн хэдэн жилд тохиогоогүй хүйтэн өвөл болно гээд байдаг. Нэг иймэрхүү янзтай бүтэн жил сонгуулиар амьсгаллаа. Үр дүнд нь монголчууд бид өвөл болохыг мартсан аятай бэлтгэлээ ч базааж чадаагүй шахам л сууна. Ийм байж таарах уу даа, энэ чинь. Сая хэд хоног хөдөөгөөр явлаа. Хаа сайгүй л сонгуулиас болж огт ажил урагшлаагүй талаар ярьж, ийм хууль санаачилсан, өргөн барьсан, өөрчилсөн хүмүүсийг дүүжилбэл таарна гэж зүхэж сууна. Зүхэхгүй гээд ч яах юм билээ, өөр аргагүй.

Ёстой л ийм хогийн хууль гаргасан нөхдүүдэд хариуцлага тооцож болдог бол тооцох юмсан. Уг нь сонгуулийг нь ингэж хоёр хувааж хийгээд байх шаардлага ч байхгүй. Системээ тохироод л, УИХ болоод орон нутгийн сонгуулиа нэг дор хийчихээд болно. Нэгдүгээрт, өчтөчнөөн тэрбум төгрөг хэмнэнэ. Тэр хэмнэсэн мөнгөөрөө арай өөр зүйл хийж болно шүү дээ. Манай улсад юу л байна, асуудал л байгаа. Сургууль, цэцэрлэгээс авахуулаад. Тэгээд ч эдийн засаг хүндрэлтэй. Ер нь ингэж жилд, хоёр гурван удаа сонгууль хийгээд байх хөрөнгө мөнгөтэй, баян улс биш, манайх. Дээрээс нь, монголчууд хэчнээн тэнэг байлаач сонгуулиар хэдэн хүний нэр дугуйлчихтайгаа байгаа. Тиймээс ингэж УИХ, орон нутаг гэж хоёр тусдаа сонгуульдаад бах ямар ч шаардлага байхгүй шүү дээ. Хэрвээ өнгөрсөн зургадугаар сард УИХ, нийслэл, орон нутгийн сонгуулийг нэг дор явуулчихсан бол өнөөдөр улс орны ажил арай л өөр, урагшилчихсан байх байсан юм. Мөн эдийн засаг элгээрээ мөлхөж байгаа энэ үед хэдэн тэрбум төгрөг хэмнэчих л байсан. Сая орон нутгийн сонгуулиар 10 гаруй тэрбум

ӨӨР ӨНЦӨГ

Байгалийн нөөцийн ЗАСАГЛАЛ ба ХАРААЛ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Баялгаасаа хувь хүртэх өч төчнөөн том ордууд, төрийн өмчит компаниуд. Бүгд алдагдалтай. Бөөн өр шир. Эрдэнэс Тавантолгойн Чалкогийн өр, Эрдэнэтийн Жастын Батхүүгийн өр, Оюутолгойн өр, Чингис, Самурай бондын өр гэх мэтээр явж өгнө. Улсаараа өрөнд орсоор 21.5 тэрбум ам долларын өртэй болжээ. Он гараад Чингис бондын эхний төлөлт болох 500 сая ам доллар төлнө. Юугаараа төлнөө!? Төгрөг нь хогийн цаас болтлоо үнэгүйдсэн. Ингээд харахаар

бидэнд баялгийн хараал гэдэг нь бодитоороо нүүрлэчихэж. Асар их баялагтай ч авлига, хээл хахуульд идэгдэж баялгийн хараал хүртсэн Зимбабвед иргэд нь үндэснийхээ тэрбум доллароор талх ч авч чадахгүй болтлоо дампуурч, өлсгөлөн гуйланчлалд нэрвэгдэж буй муу жишээг бид харж байна. Дараагийн Зимбабве болохгүйн тулд байгалийн баялгийн засаглалаа сайжруулах алсын хараатай бодлого хэрэгжүүлэх шаардлага ус агаар мэт хэрэгтэй болжээ. Биднийг бие биенээ хардаж, хулгайч, луйварчин, хужаа жунгаагаараа дуудалцан цаг алдаж

суух зуур бусад улс орнууд хөгжлөөрөө тасраад явчихлаа. Японд сансрын аялал жуулчлал хөгжиж дэлхийн агаар мандалаас гарч зугаалах, хүн шиг роботуудаар гэрийн зарц хийх, Америкт нар салхины эрчим хүчээр ажилладаг машин, байшинг массаар нь үйлдвэрлэх, хүний эд эрхтэнг нано технологиор ургуулах төсөл биелэлээ олж тун удахгүй энгийн хэрэглээ болох нь. Атаархах юм. Бид одоо яах вэ? Явал дээр вэ? . Эрдэнэтийн 49 хувийг ямар ч шийдэл гаргалгаагүй ярьсаар буцаагаад Оросуудад өгөх үү? Тавантолгойн хэрүүлээ үргэлжлүүлж, 200 ам

доллар хол давсан үнэтэй нүүрсээ 30 гаруйхан ам доллароор хил давуулж урсгасаар суух уу? Аль эсвэл өргөн, нарийн цариг, танк дайн ярьж төмөр замаа гацаах уу? Улс орноо алах, аврах эсэх нь эрх баригчид та нараас л хамаарна. Алдах эрхгүй. Төрийн өмчит компаниуддаа алсын хараатай зоримог шийдвэрүүд гаргаж, заримыг нь хувьчлах, заримынх нь засаглалыг сайжруулах замаар байгалийн нөөцийн баялгаа хөгжил, дэвшилд хөрвүүлэх боломжийг ашиглаасай! Америк, Япон шиг болж чадахгүй ч байгаа баялгаа зүй зохистой ашиглаад өр ширнээсээ гарчих юмсан.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“
 ᠐ᠣᠳᠡᠡᠢ ᠠᠭᠡᠭᠢ ᠴᠠᠭᠠᠠᠢ ᠶᠡ
 ᠰᠢᠨᠠᠳᠤᠠ ᠠᠭᠠᠭᠠᠢ ᠵᠡ,
 ᠠᠶᠡᠭᠡᠭᠡᠢ ᠠᠳᠠᠭᠠ ᠠᠶᠢ
 ᠢᠳᠢᠠᠳᠠᠵᠢ ᠢᠶᠡᠨᠡᠭᠡᠡᠢ
 ᠰᠢᠨᠠᠳᠤᠠ ᠵᠡᠭᠡᠭᠡᠢ
 ᠠᠶᠡ, ᠠᠶᠡᠭᠡᠢ ᠠᠵᠢᠳᠤᠶᠠ
 ᠠᠢᠶᠡᠢ ᠢᠢ.”

Баялаг дүүргийн Засаг дарга
 С.Одоотуяа

Гэрэл зурагийг Г.АРТУУЖИН

МЭДЭЭЛЭЛ

ЭДИЙН ЗАСАГТ ОНЦГОЙ АЧ ХОЛБОГДОЛТОЙ
ТӨСЛҮҮДЭЭ ТАНИЛЦУУЛАВ

Нийгэм эдийн засгийн таагүй үед шинээр бүрэлдсэн Засгийн газар 100 хоногт эдийн засгийг тогтворжуулах суурь үндэслэлүүдээ боловсруулж, хэтийн төлөвт уялдуулсан олон бодлого шийдвэрүүд гарган ажиллаж байгаа билээ. Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийг УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан УИХ-ын гишүүд салбарын яамдын санал бодлыг сонсож, бодлого шийдвэрээ нэгтгэх үүднээс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, хөтөлбөрүүдтэй танилцаж байна.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагууд “Эдийн засгийн хүндрэлээс гарах, тогтворжуулах хөтөлбөр”-т тусгасан төсөл хөтөлбөр, арга хэмжээний танилцуулгыг өнгөрөгч баасан гаригт хийлээ. УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ж.Энхбаяр, Я.Содбаатар, Г.Занданшатар болон ажлын хэргийн гишүүд ЗТХЯ-д ажиллаж, Хямралыг даван туулах хөтөлбөрөө ийнхүү эцэслэн ярилцсан юм.

Тус яамнаас улс орны эдийн засагт онцгой чухал ач холбогдолтой нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай 6 гол төсөл хөтөлбөрийг онцлон танилцууллаа.

- Үүнд:**
1. Иргэний нисэхийн үйлчилгээнд Олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, энэ ажлын хүрээнд харилцан ажиллах чадвар бүхий систем болон өгөгдлийн нэгдсэн системийг бий болгох
 2. Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэр гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг эцэслэн байгуулах, хэрэгжүүлэх
 3. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах
 4. Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт туссан Эрдэнэт-Овоот, Хөт-Бичигт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх
 5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг дуусгах
 6. Богдхан төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх зэрэг ажлуудыг онцолсон юм.

Дамжин өнгөрөх нислэгийн тоог 5–10 хувиар нэмэгдүүлэх боломжтой

Иргэний нисэхийн үйлчилгээнд Олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан дэвшилт

тэт техник технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд харилцан ажиллах чадвар бүхий систем болон өгөгдлийн нэгдсэн системийг бий болгосноор агаарын хөлгийг тохиромжгүй нислэгийн өндөрт орохоос сэргийлэн удаан хугацаагаар түлш зарцуулахыг зогсоох давуу талтай талаар тус яамнаас мэдээллээ. Мөн агаарын зайн багтаамж нэмэгдэж, дамжин өнгөрөх нислэгийн тоог 5-10 хувиар нэмэгдүүлэх ач холбогдолтой аж. Гол давуу тал нь тодорхой тооны зөрчлийг бууруулах бөгөөд үр ашигтай агаарын замыг бий болгох зорилготой юм.

Дэлхийн зах зээлд өрсөлдөх бас нэгэн боломж

Сүүлийн жилүүдийн ачаа, зорчигч тээвэрлэлтийн хэрэгцээ, шаардлага өсөн нэмэгдэж, хөрш орнууд төдийгүй гуравдагч орнуудтай автотээврийн сүлжээг өргөжүүлэх боломж, шаардлага үүсээд байгааг дээрх танилцуулгын үеэр ЗТХЯ-ны удирдлагууд онцлолоо. Азийн авто замын сүлжээгээр автотээвэр гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг эцэслэн байгуулах, хэрэгжүүлэх зорилготой юм. Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар Монголын тээвэрчид гуравдагч улс орнууд руу тээвэрлэлт гүйцэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх, дамжин өнгөрөх тээвэрлэлтийн шинэ гарц нээгдэх эрх зүйн зохицуулалт



бий болох юм. Мөн Монгол Улс болон гуравдагч орнуудын хооронд ТИР конвенцийн хүрээнд ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах боломж бүрдэхээс гадна Монгол Улсын гадаад худалдаа өргөжиж манай улсын эдийн засагт эерэгээр нөлөөлнө гэдгийг ЗТХЯ-ыхан танилцууллаа. Ингэснээр Ази-Европыг хамарсан худалдаа, тээвэр, гааль, татвар, даатгалын асуудлууд хөнгөвчлөгдөж, авто замын дамжин өнгөрөх тээвэрлэлт эхлэхтэй холбогдуулан Азийн авто замын сүлжээний АНЗ

болон АН4 авто замуудад орчин үеийн дэвшилтэт авто замын тоноглол, төлбөр хураах системийг нэвтрүүлэх, олон улсын авто замын дагууд жолооч, зорчигчдын ая тухтай амрах үйлчилгээний цогцолбор, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний төвүүдийг байгуулах зэрэг боломжууд бүрдэнэ гэдгийг хэллээ.

Тээврийн зардлыг гурав дахин бууруулах боломжтой

Зам, тээврийн хөгжлийн яамнаас эдийн засагт ач холбогдолтой хэмээн үзэж буй бас нэгэн төсөл бол Эрдэнэт-Овоот, Хөт-Бичигт чиглэлийн төмөр зам. Зүүн хойд Азийн эдийн засгийн бага хурлаас 2000 онд тээврийн коридорыг тодорхойлсон нь бий. Эдгээр коридорын нэг нь Монгол Улсын төмөр замын хэтийн төлөвтэй уялдуулан “Боорж-Эрэнцав-Чойбалсан-Хөт-Бичигт-Чанчунь чиглэлийн улс, бүс нутгийн хамтын ажиллагааны хөгжилд чухал ач холбогдолтой” гэж тэмдэглэл гарсан байдаг. Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Хөт-Бичигт чиглэлийн 216 км төмөр замыг нарийн царигийн стандартын буюу 1435 мм-ийн царигтай байхаар тусгасан. Энэ нь цаашлаад БНХАУ-ын төмөр замаар дамжин өнгөрч далайн боомтоор гуравдагч оронд бүтээгдэхүүн тээвэрлэх боломж үүсэх юм. Уул уурхайн экспортоос хамааралтайгаар



өсөж буй эдийн засагтай орны хувьд эрсдэлийг бууруулах нэг арга зам нь үнийн ба үнийн бус өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломж болох төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх ёстой. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр нүүрсний экспортыг дэмжихээс гадна Монголын нутаг дэвсгэрийн доторх тээврийн өртгийг бууруулах боломж бүрдэх юм. Мөн орон нутагт ажлын байр нэмэгдэн, дэд бүтцийн сүлжээ хөгжиж, Монгол Улсын экспортын өрсөлдөх чадвар дээшлж, тээвэрлэх гол ачаа болох

нүүрсний Монгол Улсын нутаг дэвсгэр дэх тээврийн зардлыг 2.5-аас 3 дахин бууруулах давуу талтай гэдгийг ЗТХЯ-аас ажлын хэргийнхэнд танилцууллаа. Хөт-Бичигт чиглэлд жилд 23.9 сая тонн ачаа тээвэрлэнэ гэсэн судалгаа гарсан байгаа бөгөөд төмөр замын тээврийн тарифыг 3.3 ам.долларын цент байхаар тооцсон бөгөөд хөрөнгө оруулалтаа 11.6 жилд нөхөх тооцоог гаргаад байгаа аж.

Үүнээс гадна төмөр замын хойд коридорын Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ашиглалтад орсноор Хөвсгөл, Булган, Орхон аймгийн ашигт малтмалын орд газруудын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх, тухайн бүс нутгийн худалдааны тээврийг хөнгөвчилснөөр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон түлхэц болно хэмээн тооцоолжээ. Эрдэнэтийн салбар шугамыг өргөжүүлснээр Монгол Улсын баруун хойд бүс нутгийн ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг нээж жилдээ 10-15 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэх, цаашид ОХУ-ын Тува улсын Кызылтэй холбогдсоноор Тувагийн 14 тэрбум тоннын таамаг нөөц, 2,5 тэрбум тоннын батлагдсан нөөц бүхий Улуг-Хемийн нүүрсний сав газрын ордуудаас жилдээ 47 хүртэлх сая тонн нүүрсийг Монгол Улсаар дамжуулан тээвэрлэх бололцоотой болох юм байна.

Энэхүү төмөр зам ашиглалтад орсноор эхний жилд 10 сая тн ачаа тээвэрлэх бөгөөд хоёр дахь жилээс эхлэн тээвэрлэх ачааны хэмжээ ихсэж, жилд 20 хүртэл сая тн ачаа тээвэрлэх аж.

Уул уурхайн экспортоос хамааралтайгаар өсөж буй эдийн засагтай орны хувьд эрсдэлийг бууруулах нэг арга зам нь үнийн ба үнийн бус өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломж болох төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд үүнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөл чухал ач холбогдолтой. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монголын эдийн засгийн хүндрэлтэй байдлыг даван туулахад дорвитой хувь нэмэр оруулна гэдгийг Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлагууд хэллээ. Энэхүү төсөл 2019 онд

ашиглалтад орвол 2020 онд ашиглалтын үйл ажиллагаанаас хамаараад аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 43.8 тэрбум төгрөг төлөх боломжтой жишээг дурдлаа.

Нийслэлчүүдийн тулгамдаад буй асуудлыг Богдхан төмөр зам төсөл шийднэ

Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дэвсгэрт байрлах Улаанбаатар төмөр замын Рашаант өргөнөөс салбарлан Улаанбаатар хотыг баруун урд талаар Богдхан уулын өвөрт байрлах Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдаж буй Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын орчмоор дайран тойрон гарч Улаанбаатар төмөр замын Мааньт өртөөтэй холбогдох шинэ “Богдхан” төмөр замыг барих урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл, чигийн зураг төслийг бэлтгээд байгааг танилцууллаа. Энэхүү төмөр замын шинэ шугамыг барьж байгуулснаар Улаанбаатар төмөр замын дамжин өнгөрөх болон бусад ачаа тээврийг түүгээр явуулж, Улаанбаатар хотын дундуур өнгөрч буй төмөр замын одоогийн шугамаар зөвхөн олон улсын болон орон нутгийн зорчигчийн галт тэргийг явуулах, мөн шугамыг хотын нийтийн зорчигч тээвэрт ашиглах бололцоо бүрдэх аж.

Улаанбаатар хотын дундуур гарч байгаа төмөр зам хотыг хоёр хэсэгт хуваадаг тул түгжрэлийн гол хэсэг нь хот орчмын нутаг дэвсгэрт байрлах төмөр зам, авто замтай огтлолцсон 32 гарам байдаг аж. Ачааны галт тэргийг хот дундуур явахгүй болгосноор босоо тэнхлэгийн авто замуудаар саадгүй нэвтэрч авто замын түгжрэл буурах ач холбогдолтой юм байна. Мөн төмөр замаар явж буй транзит болон экспорт, импортын ачаануудын дотор бүх төрлийн хортой, тэсэрч дэлбэрэх аюултай, химийн хортой ачаанууд дайран өнгөрч нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл байдлыг зөрчиж байгаа асуудал шийдэгдэх юм байна. Түүнчлэн Улаанбаатар хотын хүн амын төвлөрөлтэй холбоотой сүүлийн үед нэмэгдэж буй хүндрэлүүд болох галт тэргэнд дайрдаг ачааны галт тэргэг авто машинтай мөргөлдөх ослоуд гарахгүй, иргэдийн аюулгүй байдлыг хангах давуу талтай хэлж байлаа. Үүнээс гадна төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний дуу чимээнээс үүдэн хотын оршин суугчдад учруулж буй дуу шуугианы бохирдлыг арилгах ач холбогдолтой бөгөөд 35 км энэхүү төмөр замын хотын зорчигч тээврийн зориулалтаар ашиглан хөнгөн галт тэргэний үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой аж.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Шивээхүрэн боомт дахь авто замын засвар ашиглалтын байдалтай танилцжээ

Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох албаныхан Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомт дахь улс хоорондын ачаа тээвэрлэлт, хүнд даацын авто замын засвар ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын ажилтай танилцжээ. Тээвэрлэлт, авто зам ашиглалтын үйл ажиллагаа нь холбогдох дүрэм, журам, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн зөвлөмж чиглэл өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилгоор ийнхүү газар дээр нь очиж танилцсан байна.

Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хүнд даацын авто зам дээр хоёр төлбөр хураах цэг, хөдөлгөөн зохицуулах хөдөлгөөнт гурван эргүүл ажилладаг бөгөөд долоо хоногийн ням гаригаас бусад өдрүүдэд 08:00-23:00 цагийн хооронд замын хөдөлгөөнийг тасралтгүй хянадаг байна. Концесс эзэмшигч “Ар Ди Си Си” ХХК-тай тээвэрлэгч 30 аж ахуйн нэгж авто зам ашиглах гэрээ байгуулж, өдөрт дунджаар 400-500 автомашин, сард дунджаар 750,0 мянган тонн нүүрс тээвэрлэж байгаа мэдээлэл байна. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 43.2 км хүнд даацын авто замын 23 дахь км-т түр зогсох талбай гаргасан байдаг бөгөөд нүүрс тээвэрлэж буй автомашинууд зориулалтын зогсоолдоо багтахгүй замын далайн хөндийг болон хөвөөн дээр олноор зогсох, зам руу орж, гарах зэргээс хөвөөний шороо суларч суулт үүсч, хучилгын ирмэг эмтэрч, гэмтсэн байгааг албаныхан мэдээлсэн. Мөн “АТҮТ” ХТҮ-ын Шивээхүрэн боомт дахь салбарт ажиллаж буй автотээврийн хяналтын улсын байцаагч, тээвэр зохицуулагчид амьдрах байргүй тул тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм байна.

Тэрхийн голын гүүр хэвийн ажиллаж байна

Архангай аймгийн Тариат сум, Цэцэрлэг-Госонцэнгэл чиглэлийн улсын чанартай авто замд байрлах Тэрхийн голын 217.1 у/м төмөр бетон гүүрэнд их засварын ажил гүйцэтгэж байгаа билээ. Үүнтэй холбогдуулан тээврийн хэрэгслийг тус голоор саадгүй нэвтрүүлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яам болон Зэвсэгт хүчний жанжин штабын хооронд байгуулсан гэрээний дагуу хөвдөг гүүрийг өнгөрсөн долдугаар сарын 08-ны өдрөөс Тэрхийн гол дээр дэлгэн ажиллуулж, энэ сарын 08-ны өдөр хурааж авчээ. Хөвдөг гүүрийг ажиллуулахдаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, хөдөлгөөний аюулгүй байдал, зам хэрэглэгчийн тав тухтай зорчих нөхцлийг хангахад онцгой анхаарч гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлсэн Зэвсэгт хүчний жанжин штабын хамт олонд Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс талархал илэрхийлэв. Төмөр бетон гүүрийн их засварын ажил дуусаагүй байгаа боловч 30 тн даацын хязгаарлалттайгаар үндсэн гүүрээр зорчих болсныг тус яамнаас иргэд, олон нийтэд мэдээллээ.

ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

ТЭНГЭРТ ЦОЙЛСОН АМ.ДОЛЛАРЫН ХАНШ

Ам.долларын ханш өдөр өдрөөр нэмэгдсээр, 2400 төгрөгийг давсан. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт “Найман шарга” валютын захад 2700 төгрөгийг давж, цаашлаад 3000-д хүрвэ. Ердөө л хэдэн ченж валютын ханшаар тоглож, зөрүүн дээрээс ашиг олсон гэсэн үг. Мэдээж Засгийн газар, Монголбанкнаас энэ асуудалтай холбоотойгоор тодорхой хэмжээнд байр сууриа илэрхийлж, мэдэгдэл хүртэл гаргасан. Тиймдээ ч хэсэг зууртаа л хөөсрөөд байсан ам.долларын ханш эргээд бага сага буурч эхэллээ. Тэгвэл “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Онцлох хуудас”-таа ам.долларын ханшийг онцолж байна. Ерөөсөө өнгөрсөн долоо хоногийн гол дуулиан шуугиан ам.долларын ханш л байлаа. Тиймээс өнгөрсөн долоо хоногт өрсөн нөхцөл байдал болоод зарим эдийн засагчдын байр суурийг онцолж байгаа юм.

Ам.долларын ханш 220 төгрөгөөр огцом буурлаа

2016.11.11

Арилжааны банкуудад ам.доллар дуудлага худалдаагаар худалдсан гэсэн мэдээлэл цацсаны дараа Монголбанк дахин нэг мэдээлэл гаргасан юм. Тэр нь ам.долларын ханш огцом буурч байгаа талаар. Тус мэдээлэлд “Монголбанк өчигдрөөс эхлэн бий болсон ханшийн огцом хөдөлгөөнийг эсрэг шийдвэртэй арга хэмжээ авахаа мэдэгдээд буй. Энэ хүрээнд өнөөдөр гадаад валютын ээлжит бус дуудлага худалдаа зохион байгуулж, валютын захад 72.4 сая ам.доллар, 73 сая юань тус тус нийлүүлээд байна. Тэгвэл дуудлага худалдаа зохион байгуулснаас хойш ам.долларын ханш огцом буурч эхэллээ. Тодруулбал, 14:30 цагийн үед “Найман шарга”-ын ченжүүд нэг ам.долларыг 2720 төгрөгөөр зарж байсан бол 16:30 цаг гэхэд энэхүү ханш 2500 төгрөг болж, огцом буурсан байна. Харин арилжааны банкууд нэг ам.долларыг дунджаар 2470 төгрөгөөр зарж байна. Монголбанк энэ удаагийн ханшийн огцом өсөлтийг тэнцвэрт түвшнээсээ хэт хөөсөрсөн, түр зуурын шинжтэй гэж үзэж буй бөгөөд огцом хэлбэлзлийг тогтворжуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна гэдгээ мэдэгдсэн билээ” хэмээсэн юм.

Монголбанк арилжааны банкуудад 72.4 сая ам.доллар зарлаа

2016.11.11

Интервенци хийх ам.доллар байхгүй, 1.2 тэрбумынхаа нөөцийг багасгахгүй хэмээн мэдэгдэж байсан Монголбанк баасан гарагт яаралтай арга хэмжээ авлаа. Тодруулбал, тус банкнаас “spot арилжаа: Монголбанк ээлжит бус дуудлага худалдаа зарлаж, банкууд 2450.00-2490.00 төгрөгийн ханшаар 72.4 сая ам.доллар, 358.23-364.00 төгрөгийн ханшаар 73.0 сая юань худалдан авах санал ирүүлсэн. Монголбанк 2450.00 төгрөгийн нэг ханштайгаар ам.доллар, 358.23 төгрөгийн нэг ханштайгаар юанийн саналыг тус тус 100 хувь биелүүллээ” хэмээн мэдээлэв.

Монголбанк: Ханшийн огцом хэлбэлзлийг тогтворжуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна

2016.11.11

Сангийн сайд мэдээлэл хийж, ам.долларын ханшийг Засгийн газар анхааралтай ажиглаж байгаа, бид асуудлыг шийдэхээр хэлэлцээр хийж байна гэх мэтээр тайлбар хийсний дараа Монголбанк мэдэгдэл гаргасан. Тухайлбал, “Төгрөгийн гадаад валюттай харилцах ханш сүүлийн хоногуудад огцом сулраад байна. Үүнийг Монголбанк тэнцвэрт төвшнөөсөө хэт хөөсөрсөн, түр зуурын шинжтэй гэж үзэж байна. Монгол Улсын Засгийн газрын Олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчтай хийх хэлэлцээр үр дүнтэй болж, ойрын хугацаанд санхүүжилтийн асуудал шийдэгдэхээр болсон. Монголбанкнаас ханшийн энэхүү огцом хэлбэлзлийг тогтворжуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна гэдгийг мэдэгдэж байна” хэмээжээ.

Б.Мөнхзаяа: Ам.долларын хадгаламжийн хүүг 2-3 дахин бууруулах хэрэгтэй

/СЭЗДС-ийн багш, эдийн засагч/
2016.11.11

Ам.долларын ханшийг тогтворжуулахын тулд ойрын хугацаанд төр засгаас хэрэгжүүлж болох нэг арга байна. Экспортын орлогыг өсгөх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бол урт хугацаандаа хийх ёстой ажлууд л даа. Тиймээс ойрын хугацаанд ам.долларын эрэлт дээр анхаарах хэрэгтэй. Аравдугаар сарын статистикийн мэдээг харахад, ам.долларын хадгаламж нэлээд өссөн байна. Энэ нь ам.долларын эрэлтийг нэмэгдүүлсэн гэсэн үг.

Тэгэхээр хамгийн түрүүнд ам.долларын хадгаламжийн хүүг бууруулах хэрэгтэй. Өнөөдөр төгрөгийн хадгаламж 16, ам.долларын хадгаламж 10 хувьтай байгаа. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн хүү нь тийм ч ялгаатай биш байна.

Гэтэл оны эхнээс ам.доллар 26 хувиар өссөн. Дээр нь хадгаламжийн 10 хувийн хүүгээ нэмэхээр нэг ёсондоо 36 хувийн ашгийг ам.долларын хадгаламжаас хүртэж байна гэж хэлж болно. Тиймээс ам.долларын хадгаламжийн хүүг одоо байгаагаас нь 2-3 дахин бууруулах хэрэгтэй. Тэгж байж л ам.долларын хий хоосон хөөрөгдлийг багасгана. Эрэлтийг бууруулна. Энэ бол ойрын хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэж бодож байна.

Б.Чойжилсүрэн: Валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай, энэ чиглэлээр хэлэлцээр хийж байна

2016.11.11

Сангийн сайд Б.Чойжилсүрэн 2017 оны төсөв батлагдсантай холбоотойгоор өнгөрсөн баасан гарагт мэдээлэл хийсэн билээ. Энэ үеэрээ ам.долларын ханштай холбоотойгоор тайлбар хийсэн юм. Тэрбээр “Ерөнхий сайдын зүгээс Сангийн яаманд үүрэг өгсөн. Тухайлбал, бүх төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтийг хийх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах гэх мэтчилэн. Бодит гарц бол валютын урсгалыг нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ чиглэлээр яг одоо хэлэлцээр явж байна” хэмээсэн.



Сэтгүүлчийн өнцөг

АМ.ДОЛЛАРЫН ӨСӨЛТӨД ЗАСГИЙН ГАЗАР БУРУУТАЙ

Н.ПУНЦАГБОЛЦ

Ам.доллар сүүлийн гурван сарын турш сард тав орчим хувиар төгрөгийн эсрэг чангарсан талаар эдийн засагчид мэдээлж байгаа юм. Ерөөсөө сонгуулийн дараа Сангийн сайдын хийсэн мэдэгдлээс эхлээд л асуудал босч ирсэн. Мань хүн ч яах вэ, мэдэгдлээ зөв байсан гээд л зүтгээд байгаа. Яах вэ, мэдэгдэж, үнэнийг хэлж болно, гэхдээ арай өөрөөр хэлэх байсан юм. Түүнээс хойш ам.долларын ханш нэмэгдсээр, төгрөг суларсаар л байгаа. Одоо бүр амаа авч давхидаг морь шинг боллоо. Монголбанк энэ хугацаанд ажлаа хийсэн үү, хийсэн. Бодлогын хүүгээ өсгөж, хурдтай өсч байсан ам.долларын ханшийг

нэг хэсэгтээ л барьсан. Мэдээж Монголбанкнд интервенци хийгээд байх ам.долларын нөөц гэж бараг байхгүй байгаа. Тэгэхдээ хэдэн сая ам.доллар зах зээлд гаргаад л байсан. Харин сүүлийн үед ганц хоёр удаа ам.доллар дуудлагаар худалдаагүй. Яах вэ, нөөцгүй шахам болохоор яаж худалдах билээ дээ. Энэ хооронд Засгийн газар юу хийв. Гаднаас зээл авах, ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах асуудлаа ярьсаар, ярьсаар л суусан. Одоо болтол асуудлаа шийдэж дуусаагүй л байна. Ганц нэг гэрэлтэй мэдээ дууддаж эхэлсэн. Гэвч хэзээ вэ гэдэг нь бас тодорхой биш. Ядаж байхад, өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар Ерөнхий сайд Сангийн сайдаа

ам.долларын ханшийн өсөлтийг бууруулах үүрэг өгсөн. Арилжааны банкууд Монгол банкны зарласан ханшаас өндөр үнээр ам.доллар зарахгүй байх боломжийг судал гэх мэт цөөнгүй хэдэн үүрэг өгсөн юм. Үндсэн санаа нь Монгол Улсад бүх гүйлгээг төгрөгөөр хийх хуулийн хэрэгжилтийн хангалтыг сайжруулахад чиглэсэн. Тэгвэл эдийн засагчид энэ шийдвэрийг олон нийтэд мэдээлсэн нь ам.долларын ханш өсөхөд багагүй нөлөөлсөн гэдгийг ч хэлж байна. Ерөөсөө Засгийн газар шийдвэртэй арга хэмжээ авах нь, ам.доллар олдохгүй болохоос өмнө гялс худалдаад авья гэсэн бодолтой хүмүүс ихэсч, эрэлт эрс өссөн нь ханш дагаад огцом нэмэгдэх шалтгаан

болчихлоо. Ингээд л хоёр, гурав хоног хэдэн ченжүүд л башийлаа. Засгийн газар ямар ч шийдвэр гаргаж болно. Гэхдээ заримыг нь ард түмэнд мэдээлэхгүй байх хэрэгтэй шүү дээ. Тэр дундаа ханшийн өсөлтөд нөлөөлөхөөрийг нь. Өнөөдөр хүлээлт нэг талдаа гарчихаад байгаа. Үндсэндээ бүгд л ам.доллар өснө гээд л, түүн дээр нь тоглоод ашиг олох талаар бодоод байна. Иргэд ч гэсэн эх орон ч сэтгэлгээгүй, төгрөгийн хадгаламжаа ам.доллар руу шилжүүлэхээр хуйларч эхэллээ. Тэгвэл энэ хүлээлтийг нь нөгөө талд нь гаргах мэдэгдэл, мэдээллийг л Засгийн газар, Монголбанкнаас гаргаж баймаар байна. Өнгөрсөн баасан гарагт Монголбанкны хийсэн мэдэгдлийг

зөв зүйтэй гэж дэмжих гээд байна л даа. Иймэрхүү мэдээлэл, мэдэгдлийг Засгийн газар ч хийх л хэрэгтэй. Ерөөс хүлээлт дандаа л ам.доллар өсөхгүй гэх талд байхаар мэдээллийг нийгэмд цацаад байж яагаад болохгүй гэж. Тэгээд огцом савлагаа үүсэхгүй, тогтвортой байвал болоод явчихна. Ер нь бол ирэх долоо хоногоос ам.долларын ханш огцом буурна гэж эдийн засагчид харж байгаа юм билээ. Түр зуурын хөөсрөлийн шинж чанартай учраас мэдээж буурна. Харин хэдэн төгрөгт нрж тогтохыг харах л үлдэж. Гол нь Засгийн газар л хурдан хөдөлж, валютын орох урсгалаа нэмэгдүүлэх ажлаа яаравчлаасай билээ.

ДЭЛХИЙ

АНУ-ын төрийн тэргүүн тодорч, СОЛОНГОСЧУУД ЕРӨНХИЙЛӨГЧӨӨ ЭСЭРГҮҮЦЭН ЖАГСЛАА

Д.ДАВААХҮҮ

Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа болсон онцлох үйл явдлыг тойлон хүрээж байна.

АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчөөр Д.Трамп сонгогдоо

Төрийн тэргүүн болон гүйцэтгэх засаглал болох Засгийн газрын тэргүүн гэсэн чухал албыг толгойлох Нэгдсэн улсынхамгийн “хүчирхэгхүн”-ийг сонгох сонгууль өнгөрсөн долоо хоногийн мягмар гарагт боллоо. Улмаар улс төрийн туршлагагүй, цэргийн алба ч хааж үзээгүй, үл хөдлөх хөрөнгийн бизнесмен Доналд Трамп төлөөлөгчдийн олонхийн саналыг авч, АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчөөр сонгогдоо. АНУ-ын Ерөнхийлөгч таван мянга гаруй төрийн албан хаагчдыг шууд томилж эрхтэй, дэлхийн хамгийн том, 17 гаруй их наяд ам.долларын ДНБ-тэй эдийн засгийг удирдах, 1.3 сая гаруй цэрэгтэй зэвсэгт хүчний ерөнхий командлагч гэсэн үүргүүдийг гүйцэтгэдэг. Харин энэ удаа үл хөдлөх хөрөнгийн бизнесийн салбарт унаж, босч явсанаас өөрөөр цэргийн алба хааж үзээгүй, улс төрд ажилласан туршлагагүй тэрбумтан эр энэ бүх эрх мэдлийг гартаа атгалаа. Сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон, БНН-аас Доналд Трамп өрсөлдсөн. Улмаар Трамп 279 төлөөлөгчийн саналыг авч, илт давуугаар ялалт байгуулсан бол сонгууль угтсан санал асуулга хийгээд, халз мэтгэлцээнүүдэд илт давуу тэргүүлж явсан Хиллари Клинтон өвдөг шороодсон билээ. АНУ-ын шинэ Ерөнхийлөгч ирэх оны нэгдүгээр сарын 20-нд Ерөнхийлөгчийн тангарагаа өргөх бөгөөд тус улсын 48 дахь дэд Ерөнхийлөгчөөр Майк Пенс ажлаа эхлэв. Флорида мужийн Миами, Орландо, Нью Йорк, Оргеон мужийн Портланд, Жоржиа мужийн Атланта, Пенсилванийн Филадельфия, Массачусетсын Бостон, Мичиганы Детройт, Техасын Даллас, Теннеси мужийн Мемфис, зэрэг хотуудад Доналд Трамп ялалтаа зарласнаас хойш гурван шөнө, гурван өдрийн турш эсэргүүцлийн жагсаал зохион байгуулагдсан. Энэ сарын 11-ний өдөр гэхэд Нью-Йоркийн Манхаттан дүүргийн Вашингтон талбайд 4000 орчим хүн цугларч эсэргүүцэж илэрхийлсэн бол “Union Square”, “Трамп таур”-ын өмнө ч эсэргүүцлийн жагсаал үргэлжилсээр байжээ. Шинэхэн Ерөнхийлөгчөө эсэргүүцэн жагсагчид баривчлагдаж,

...АНУ-ын шинэ Ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсоны дараа эсэргүүцлийн жагсаал тус улсад идэвхижиж байхад БНСУ-д авлигын хэрэгт нэр холбогдсон Ерөнхийлөгчөө суудлаас нь огцруулахын төлөө сая сая хүн гудамжинд гарч жагссан юм...

жагсагчдыг хүлээцтэй байхыг уриалж, харин 25000 цагдаагийн алба хаагчид бэлэн байдалд ажиллажээ. Түүнчлэн, Хөх орны ойролцоох замуудыг автобус, том оврын машинаар хаах арга хэмжээг авсан байна. Жагсаалд оюутнууд, тэтгэврийнхнээс гадна, хүүхдээ дагуулсан залуу хосууд ч оролцжээ. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн багын найз гэгддэг Чой Сун Сил гэгч Ерөнхийлөгчтэй дотно байдлаа ашиглан компаниудаас хандив нэрийдлээр их хэмжээний мөнгө авдаг байсан нь олон нийтэд ил болсон байдаг. Тэр бүү хэл, Ерөнхийлөгч Пак өөрийн хэлэх үгээ хүртэл Чой Сун Силээр засуулж, улс төрийн нууц баримт материалыг дамжуулж байсан нь ил болсноор ард түмний эсэргүүцэлтэй тулгараад байгаа билээ.

Москвад халдлага үйлдэхээр төлөвлөсөн байжээ

ОХУ-ын Аюулгүйн албанаас мэдэгдэл хийж, тус улсын нийслэл Москва, Петербург хотуудад зэвсэгт халдлага үйлдэхээр төлөвлөж байсан хэт даврагч Лалын улс бүлэглэлтэй холбоо бүхий 10 этгээдийг баривчилсан талаар олон нийтэд мэдээллээ. Тус улсын Холбооны аюулгүй байдлын товчоо баривчлагдсан 10 этгээд тов Азиас гаралтай байсан бөгөөд “Москва, Сентпетербургт анхаарал татахуйц томоохон хэмжээний дэлбэрэлт, цуврал зэвсэгт халдлага үйлдэхээр төлөвлөж байсан” гэж мэдэгдсэн байна. “Сэжигтнүүд “Лалын улс” бүлэглэлтэй холбоотой гэдгээ хүлээн зөвшөөрсөн төдийгүй, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Тажикистан, Киргизийн иргэдтэй хамтарч ажилладаг болох нь мөрдөн байцаалтын явцад тогтоогджээ. Тэд автомат буу, гар хийцийн тэсрэх бөмбөг ашиглаж, хүн ам олноор цугларсан газруудыг онилон террорист ажиллагаа зохион байгуулахаар бэлтгэж байсан байна. Улмаар ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын товчоо бямба гарагт тусгай ажиллагаа явуулж гэмт этгээдүүдийг баривчилсны зэрэгцээ гар хийцийн дөрвөн тэсрэх бөмбөг, тэслэгч, буу, сум, холбоо барих төхөөрөмж зэргийг олж илрүүлэн хураан авчээ. Тусульснхуульдаа заснаар террорист байгууллагад элсэн тохиолдолд 10-20 жилийн

гэмтэж бэртэх тохиолдол ч хэд хэдэн удаа гарсан байна. Зөвхөн баасан гарагийн шөнө гэхэд л 11 хүн баривчлагджээ.

БНСУ-ын сая иргэн Пак Гын Хег эсэргүүцлээ

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа олон улсын анхаарлыг татсан үйл явдлын нэг нь Өмнөд Солонгосчуудын өнөөгийн Ерөнхийлөгчөө суудлаасаа буухыг шаардсан тэмцэл байлаа. АНУ-ын шинэ Ерөнхийлөгчөөр Доналд Трамп сонгогдсоны дараа эсэргүүцлийн жагсаал тус улсад идэвхижиж байхад БНСУ-д авлигын хэрэгт нэр холбогдсон Ерөнхийлөгчөө суудлаас нь огцруулахын төлөө сая сая хүн гудамжинд гарч жагссан юм. Жагсаал тус улсын нийслэл Сөүл хотноо болсон бөгөөд энэ жагсаалд сая гаруй хүн нэгдсэн нь тус улсын түүхэн дэх хамгийн өргөн хүрээг хамарсан эсэргүүцлийн хөдөлгөөн болсон юм. Тус улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгч болох Пак Гын Хег суудлаасаа буухыг шаардсан жагсаал долоо хоног бүр зохион байгуулагдаж буй бөгөөд энэ сарын 12-ных гурав дахь удаагийн нь байлаа. Орон нутгийн цагдаагийн алба хаагчид уг жагсаалд 170 гаруй мянган хүн оролцно гэж урьдчилсан таамаглаж байжээ. Гэсэн ч, зохион байгуулагчдын хамгийн сүүлчийн тооцоогоор сая хүн нэгдсэн гэсэн тооцоо гарчээ. Албаныхан



хэлэлцээрийн тухай нарийвчилсан мэдээлэл өгөөгүй хэдий ч Колумбийн төлөөлөгч Хумберто де ла Калле өмнөх хэлэлцээрийн алдаа болгоныг залруулсан гэдгийг онцолжээ. Түүнчлэн, “FARC” босогчдын бүлэглэл эд хөрөнгийнхөө жагсаалтыг гаргах шаардлагатай бөгөөд үүнийг хохирогчдод нөхөн олговор олгоход ашиглана гэх заалт байгааг мөн тэрбээр дурьдсан байна. Өмнө нь “FARC” босогчидтой энхийн хэлэлцээр байгуулах эсэх талаархи бүх нийтийн санал асуулга тус улсад зохион байгуулагдаж байсан бөгөөд уг хэлэлцээрийг эсэргүүцэгчид маш бага хувийн зөрүүгээр санал асуулгад тэргүүлж байсан удаатай. Гэсэн ч, тус улсын Ерөнхийлөгч хэлэлцээрийг үргэлжлүүлнэ гэдгээ амлаж байв. Улмаар Ерөнхийлөгч Хуан Мануэль Сантосын энхийн хэлэлцээрийг Нобелийн Ерөнхий хорооноос өндөрөөр үнэлж, энэ оны Нобелийн энх тайвны шагналд тодорхойлоод байгаа билээ.

Энэтхэг 500, 1000-тын мөнгөн дэвсгэртийг гүйлгээнээс хасав

Энэтхэгт хамгийн том мөнгөн дэвсгэртүүдийг гүйлгээнээс хасч буйтай холбоотойгоор тус улсын ард иргэдийн уур бухимдал дээд цэгтээ хүрч буйг зарим эх сурвалж онцолж байна. Өнгөрсөн долоо хоногийн мягмар гарагт хийсэн мэдэгдлийнхээ үеэр тус улсын Ерөнхий сайд Нарендра Модри 500 болон 1000 рупгийн мөнгөн дэвсгэртийг гүйлгээнээс хасч, шинэ мөнгөн дэвсгэрт гүйлгэнд гаргах гэж буйгаа мэдэгджээ. Тэрбээр уг арга хэмжээг авлигын эсрэг ажиллагаа хэмээн тайлбарласан байна. Энэтхэгийн хамгийн том дүн бүхий мөнгөн дэвсгэрт болох 1000 рупи нь 15 орчим ам.доллартой тэнцдэг аж. Авлигын эсрэг энэхүү үйл ажиллагааны хүрээнд иргэд хуучин 500 болон 1000 рупигаа банкинд очиж солиулах хэрэгтэй болох бөгөөд шинээр гүйлгэнд гарах 500, 2000 рупгийн дэвсгэртэй солиулах гэнэ. Түүнчлэн, тус улсын бэлэн мөнгөний машинуудад шинэ мөнгөн дэвсгэртүүдийг унших тохиргоо хийхийн тулд хэдэн долоо хоногийн хугацаа шаардлагатай болсноор ард иргэд банкинд урт дараалан үүсгэн, бухимдах болжээ. Бүр гурав хоног дугаарласан хүмүүс ч тэдний дунд бий гэнэ. Мөн бүхэл том мөнгөн дэвсгэртүүдийг ашиглах гэсэн жолооч нар шатахуун түгээгүүрийн станцуудад урт дараалал үүсгэж эхэлсэн байна. Тус улсын Сангийн сайдын сэтгүүлдэд мэдээлсэн улсын хэмжээнд 200 мянга гаруй бэлэн мөнгөний машинд шинэ мөнгөн дэвсгэрт уншуулах тохиргоо хийх бөгөөд ингэхийн тулд 2-3 долоо хоног шаардагдах гэнэ.

Колумбийн Засгийн газар энхийн хэлэлцээрээ шинэчиллээ

Колумбийн Засгийн газар “FARC” босогчдын бүлэглэлтэй хийх энхийн хэлэлцээрээ шинэчлэн байгуулжээ. Кубад дөрвөн жилийн турш хэлэлцээ хийж байгаа талууд шинэ хэлэлцээрт сөрөг хүчин болон бусад бүлгийн саналыг тусгасан байна. Гэхдээ шинэ хэлэлцээрийг батлах эсэх санал асуулга явуулалгүй, Конгресст өргөн барихаар төлөвлөжээ. “Зэвсэгт мөргөлдөөнийг зогсоох эцсийн хэлэлцээрийг байгууллаа. Нийгмийн бүлгүүдийн санал, бодол, тодотголыг уг хэлэлцээрт тусгасан” гэж талууд хамтарсан мэдэгдэлдээ дурьдсан байна. Куба, Норвегийн дипломатууд Гаваана хотод мэдэгдлийг уншиж танилцуулсан бөгөөд шинэ

“АРИЛЖААНЫ БАНКНЫ ХҮҮНИЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ”

Манай орон эдийн засаг зах зээлийн тогтолцоонд шилжсэнээр эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн асуудал, түүний мөн чанар ихээхэн анхаарал татах болсон. Эрсдэл хэмээх ойлголт нь гадаадын тайлбар толь бичгүүдэд “байж болох, учирч болох аюул”, “эерэг үр дүнтэй болно гэж найдах” мөн түүнчлэн эрсдэх гэдэг нь “юу ч тохиолдсон бүхий л хариуцлагыг өөртөө хүлээх” гэх зэргээр тайлбарлан бичсэн байх ба өөрөөр хэлбэл эрсдэлийн сууринд ирээдүйд гарах үр дүнд бүрэн итгэхгүй, итгэл төгс бөх байх явдал оршдог. Эрсдэл гэдэг нь үргэлж түүнээс зугтаж, тойрч байх тэр л зүйл. Харин банкны эрсдэл нь өөрийн тогтолцоондоо ихээхэн бие даасан онцлогтой хэдий ч эдийн засгийн эрсдэлүүдийн нөлөөлөлд оршдог. Банкны дотоод эрсдэлүүд хоорондоо нягт холбоотой бөгөөд харилцан бие биений нөлөөлөл доор оршдог. Банк эзэл олгох, хадгаламж татах, хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагаанууд нь хүүний эрсдэлийг үүсгэдэг. Хүүний эрсдэл нь богино хугацаанд банкны нийт хүүний орлогод сөрөг нөлөө үзүүлдэг байна. Аливаа бизнесийн байгууллагын гол зорилго нь ашиглох замаар хувьнийлүүлэгчдийнхээ хөрөнгийн өгөөжийг хамгийн их байлгахад чиглэгддэг. Банкууд хоорондоо өрсөлдсөнөөр зээлийн хүүгээ бууруулах, нөгөө талаас хадгаламжийн хүүгээ тогтвортой байлгах сонирхолтой болсон. Гэвч зах зээл дээрхи энэ хоёр хүүний өөрчлөлтөөс тухайн банкны ашигт ажиллагааны түвшин буурах, тэрч

байтугай их хэмжээний алдагдалд орох эрсдэл байнга дагалдаж байдаг. Банкны эрсдэл нь дан ганц тухайн банкинд нөлөөлөлд зогсохгүй улс орны эдийн засагт нөлөөлж санхүүгийн хямралд хүргэдэг сөрөг үр дагавартай. Иймээс зах зээлийн тогтвортой бус, банкны ашигт ажиллагаа буурч байгаа энэ цаг үед хүүний цэвэр зөрүүг тодорхойлох, хүүний эрсдэлийн удирдлагыг сайжруулах зайлшгүй шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал, Сүүлийн 4 жилийн дунджаар тооцвол банкны систем дэх нийт зардлын хэмжээнд 57 орчим хувийг хүүний зардал, нийт орлогын хэмжээнд хүүгийн орлогын хэмжээ 83 орчим хувь буюу дийлэнхи хувийг эзэлж байгаа тул арилжааны банкуудын хувьд арилжааны банкны хүүний эрсдэлийн удирдлагыг судалж сайжруулах арга замыг байнга эрэлхийлж байх нь зайлшгүй шаардлагатай байна. Монгол банкнаас арилжааны банкуудад зөвлөмж зөвлөмж болгон гаргасны дагуу банкны хүүний эрсдэлийг удирдах хамгийн үндсэн, суурь аргачлал нь GAP юм. Хувьсах хүүтэй актив болон пассивын зөрүүгээр GAP илэрхийлэгдэнэ. Хувьсах хүүтэй актив гэдэгт зах зээлийн хүү өөрчлөгдөхөд түүнийг дагаад хүүг өөрчлөх шаардлагатай болдог эзэл, үнэт цаас, бусад банкинд хадгалуулсан хадгаламж, харилцах гэх мэт активууд болно. Харин хувьсах хүүтэй пассив гэдэгт мөн зах зээлийн хүү өөрчлөгдөхөд түүнийг дагаад өөрчлөх шаардлагатай болдог бусдаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламж болон бусад пассивууд орно.

Эдгээр актив, пассивууд нь тухайн таамаглаж байгаа хүүний өөрчлөлт гарахад хугацаа нь дуусах буюу дахин үнэлэгдэх эсвэл хүү өөрчлөгдөхөөр таамаглагдаж байгаа хугацаа хүртлэх хугацаанаас бага хугацаатай актив, пассивын зөрүүг тэгтэй тэнцүүлсэнээр хүү өөрчлөгдөхөд эрсдэл үүсгэхгүй явдал гэж үздэг. Өнөөдрийн байдлаар банкны салбарын хэмжээнд нийт 14 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Банкны системийн хэмжээнд GAP эерэг, банк тус бүрээр авч үзэхэд мөн адил эерэг GAP-тай байна. Энэ нь зах зээл дээрх хүүний түвшин өөрчлөгдөхөд эерэг GAP-тай банкны хувьд хүүний цэвэр орлогод сөрөгөөр нөлөөлдөг. Зээл болон хадгаламжийн хүүний түвшиний өөрчлөлтийг харвал хадгаламжийн хүүний өсөлт зээлийн хүүний өсөлтөөс өндөр байгаа нь банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж байгааг харуулж байна. Банкуудын зээлийн хүүг авч үзвэл харьцангуй ялгаатай, зээлийн хүүний хувьд хэлбэлзэл ихтэй байгаа юм. Харин хадгаламжийн хүү харьцангуй тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Банкны хүүд мэдрэмжтэй активын бүтцийг авч үзвэл 63%-г эзэл үлдсэн хувийг 3Г-н богино хугацаат фонд, гадаадын банкн дахь хадгаламж, Монгол банкн дахь хадгаламж эзэлж байна. Хүүд мэдрэмжтэй пассивын хувьд 44 орчим хувийг хугацаатай хадгаламж, 14 орчим хувийг хугацаагүй хадгаламж, үлдсэн хувийг Монгол банкны зээл репо

үнэт цаас, харилцах хадгаламж эзэлж байгаа бөгөөд эндээс харахад банкуудын эх үүсвэр бүрдүүлэлтийн зардал өндөр байгааг харж болох юм. Хугацааны хувьд задал авч үзвэл 1 жил хүртэл буюу богино хугацаатай зээл нийт хүүд мэдрэмжтэй активын 63 орчим хувийг, нийт эх үүсвэрийн 87 орчим хувийг богино хугацаатай эх үүсвэр эзэлж байгаа юм. Үүнээс харахад банкны хувьд богино хугацаанд GAP сөрөг, дунд болон урт хугацаанд GAP эерэг байна. Хүүний эрсдэлээ удирдахын тулд арилжааны банкууд зах зээлийн хүүний түвшиний өөрчлөлтийг урьдчилан таамаглаж байх хэрэгтэй. Ингэснээрээ актив, пассивын удирдлагыг оновчтой хэрэгжүүлж чадна. Зах зээлийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсэд долларын ханш, мөнгөний нийлүүлэлт, нийт хадгаламжийн үлдэгдэл, нийт зээлийн үлдэгдлийн сарын өөрчлөлт, мөн инфляцийн түвшинг авч үзэн шинжлэхэд зах зээлийн хүүний түвшин буурах хандлага ажиглагдаж байна. Зах зээлийн хүүний түвшин буурч байгаа, арилжааны банкуудын GAP эерэг байгаа энэ тохиолдолд банкууд урт хугацаатай хөрөнгө оруулалт, зээлийг дэмжих, богино хугацаат хувьсах хүүтэй пассивыг нэмэгдүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байдаг. Мөн арилжааны банкууд GAP-н шинжилгээг сар, улирал бүр тооцож, хүүний эрсдэлийг таамаглаж шийдвэр гаргалтандаа хэрэгжүүлж байх нь зүйтэй юм.

СЭЗДС-ийн магистрант Б.ЦЭРЭНЛХАМ

ШУУРХАЙ МЭДЭЭ

ӨДРИЙН ЦАГААР ГЭР БАЙШИНГ ДУЛААНААР ХАНГАХ ТӨХӨӨРӨМЖ НЭВТРҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН

Н.БАТЗАЯА

Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Батбаясгалангаас агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой асуудлаар зарим зүйлийг тодрууллаа.

-2017 оны улсын төсөвт агаарын бохирдлыг бууруулахад нэг ч төгрөг төсөвлөсөнгүй. Гэтэл нийслэлийн агаарын бохирдол дэлхийн дунджаас 5-6 дахин ихэссэн гэсэн судалгаа гарсан. Агаарын бохирдлыг бууруулахад нийслэлээс хэрхэн анхаарч ажиллах вэ?

-Шинэ нийслэлийн удирдлага дөрвөн зүйлд анхаарч ажиллана. Юун түүрүүнд бид эрх зүйн шинэчлэлийг хийх хэрэгтэй. Хэрэв эрх зүйн шинэчлэлийг хийхгүй бол Улаанбаатар хот тулгамдаж буй чухал асуудлаа шийдэх ямар ч боломжгүй болно. Эдийн засгийн хувьд ч боломж байхгүй. Гэхдээ бид тийм байлаа гээд үйл ажиллагаагаа зогсоохгүй. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд олон асуудлыг шийдэж байж бид агаарын бохирдолтой тэмцэнэ. Мөн агаарын бохирдлыг бууруулахын тулд урт хугацааны туршид тууштай цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Дулаан хуримтлуулах, цахилгаан инновацийг бий болгох, эрчим хүчний шөнийн хөнгөлөлт үзүүлэх, нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах сан байгуулж ажиллах зэргээр дорвитой арга хэмжээ авч ажиллахаар төлөвлөсөн. Мөн нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Агаарын бохирдлыг бууруулах "Утаагүй хот-2030" төслийг шинэ хэлбэрээр хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Энэ дагуу хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг хангах зайлшгүй шаардлагатай байна.

-Дулаан хуримтлуулах цахилгаан инновацийг бий болгоно гэлээ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Ер нь байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэхийн тулд төр иргэн хоёр хамтарч зөв технологийг хэрэглэх бодлого барьж ажиллаж байна. Тиймээс өмнө нь хэрэгжүүлж байсан бүрэн шаталттай зуух, сайжруулсан түлшний хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зөв системтэй үргэлжлүүлнэ. Өөрөөр хэлбэл, олон улсын байгууллагын санхүүжилт татаж агаарын бохирдлыг бууруулах

шинэ техник технологийг нэвтрүүлэх юм. Энэ хүрээнд шөнийн цагт эрчим хүч хурааж, өдрийн цагаар гэр байшинг дулаанаар хангах төхөөрөмж нэвтрүүлэхээр төлөвлөж байна. "Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах сан" (НАББС) байгуулж, түүгээр дамжуулан төхөөрөмжөө иргэдэд хөнгөлөлттэй үнээр хүргэхээр төлөвлөсөн.

-Өнгөрсөн дөрвөн жил ч гэсэн "Цэвэр агаар сан"-гаас "Утаагүй зуух" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Сүүлдээ энэ сангийн хэсэг хүмүүс мөнгө шамшигдуулсан хэрэгт холбогдож, нийслэлийн утаа ч багасаагүй шүү дээ?

-Одоо нэг зүйлийг ойлго. Утаагүй зуух гэдэг нэрнээс салах хэрэгтэй. Утаагүй зуух гэж байхгүй. Гал түлж байгаа тохиолдолд тодорхой хэмжээгээр утаа гарсаар байна. Шөнийн цагаар хямдралтай тариф хэрэгжиж байгаа энэ хугацаанд дахь эрчим хүчийг дулааны эрчим хүч болгон хуримтлуулах маргаашийн бүтэн өдрийг дулаанаар хангах технологи нэвтрүүлнэ. Энэ технологийг Монгол Улсад туршаад нутагшуулчихсан. Бид уг технологийг иргэдэд хямдралтай, эдийн засагт нь хүндрэл учруулахгүй байхад чиглэсэн шийдийг гаргасан. Тиймээс нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах сантай болно. Айл бүхэн дулаан байхын тулд нүүрс түлдэг. Нүүрсээ авахын тулд мөнгө зарцуулдаг шүү дээ. Тэгвэл

тэр мөнгөө АББС-д шингээж, тэр сангаараа дамжуулан агаарын бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ. Энэ бол Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад хэрэгжүүлж буй хамгийн том бодлого гэдгийг онцолж хэлмээр байна. Өмнө нь иргэд халамжийн бодлогоор тараасан зуухыг авч хэрэглэсэн. Харин одоо иргэн ч гэсэн харуцлага хүлээж, төр иргэн хоёр агаарын бохирдлыг бууруулахад хамтарч ажиллана.

-Иргэдээс тодорхой хэмжээнд мөнгө гарна гэсэн үг үү. Ойролцоогоор хэдэн төгрөг гарах вэ?

-Инноваци шингэсэн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний эхний гаргаж байгаа зардал бусад төхөөрөмжтэй харьцуулахад өндөр үнэтэй. Жишээлбэл, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр ажиллаж байгаа бүх технологийн гарааны өртөг өндөр үнэтэй байдаг. Мөн агаарын бохирдлыг бууруулах газарт танилцуулаад хоёр жил туршилт хийсэн "Тулга" гэдэг төхөөрөмж нь өнөөдрийн ханшаар хоёр сая 500 мянган төгрөгийн үнэтэй. Нийслэлийн барьж байгаа бодлогын хүрээнд энэхүү төхөөрмжийн үнийг 50 хувь бууруулах болмжтой. Өөрөөр хэлбэл, иргэд өөрсдөө 50 хувийг нь гаргана. Харин төрөөс үлдсэн 50 хувьд хөнгөлөлт үзүүлэх юм.

-Хаанаас нийлүүлэх вэ?
-Энэ бол Германы төхөөрөмж. Гэхдээ энэ зөвхөн жишээ болгож буй төхөөрөмж шүү.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ЦАСААР ШУУРНА

Энэ сарын 14-нд зүүн аймгуудын нутгаар, 15,16-нд баруун болон төвийн аймгуудын нутгийн хойд хэсгээр, 17-нд баруун аймгуудын нутаг, төвийн нутгийн баруун хэсгээр цас орно. Салхи 15-нд Алтайн уулсаар, 16-нд баруун аймгуудын нутгаар, 17-нд ихэнх нутгаар секундэд 18-20 метр хүрч цасан болон шороон шуурга шуурна. Мөн 14-нд нутгийн зүүн хагаст, 17-нд нутгийн баруун хэсгээр хүйтэрч бусад хугацаанд өдөртөө хүйтний эрч суларч Дархадын хотгороор шөнөдөө 22-27 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн. Увс нуур болон Хангай, Хэнтийн уулархаг нутаг, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Тэрэлж, Хэрлэн, Онон, Улз, Халх голын хөндийгөөр шөнөдөө 18-23 градус, өдөртөө 6-11 градус хүйтэн байна. Говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 10-15 градус, өдөртөө 2-7 градус хүйтэн байна. Тиймээс жолооч нарт холын замд болгоомжтой байхыг Ус цаг уурын хүрээлэнгээс анхаарууллаа.

Бактери



Бидний өдөр тутам хамгийн их ордог газар бол ариун цэврийн өрөө байдаг билээ. Өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон тэр л газар хамгийн цэвэрхэн орчин байх ёстой. Гэвч бид ариун цэврийн өрөөнд хамгийн их учирдаг аюулыг өөрсдөө бий болгодог. Энэ бол бактери. Сүүлийн жилүүдэд бактери вирусийн гаралтай өвчин ихэсч байгаа нь зарим талаараа үүнтэй холбоотой байдаг байна. НҮБ-аас 2006 онд гаргасан судалгаанаас үзэхэд дэлхий дахинд жил бүр хоёр сая хүн суултуураас бактери, вирусийн гаралтай өвчнөөр өвчилсөн гэсэн албан ёсны дүн гарсан байна. Энэ нь бидэнд аюулын харанга ойрхон байгааг харуулж байгаа болов уу. Суултуур дээр хүндээр бие засахад бидний нүдэнд үзэгдэхгүй олон тэрбум бактери суултуураас дээш цацарч байдаг байна.

Улмаар тэд ариун цэврийн өрөөн дэх бусад зүйлсэд наалдан тогтдог. Бүр таны алчуур, сойзон дээр хүртэл шүү. Тэдгээр нь бидний биед ахуйн замаар нэвтрэн ордог байна. Бид бактери гэж ярих нь элбэг байдаг ч түүний талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл, ашиг тус, хор хөнөөлийнх нь талаар мэдлэг төдийлөн хангалттай байдаггүй билээ. Манай гариг дээр бактери тархаагүй газар гэж бараг байхгүй гэж хэлж болно. Агаар, хөрс, ус, ургамал, амьтан, хүний бие цогцост ч тэд орогнож байдаг. Бактерийг судалдаг биологийн шинжлэх ухааны салбарыг бактериологи буюу нян судлал гэдэг. Бактери нь нэг эст, бие даан үржих чадвартай энгийн нүдээр үл харагдах бичил биетэн юм.

Их эмч Д.ЧУЛУУНБААТАР
Сувилагч Ц.МӨНХМАА

Мансууруулах бодистой холбоотой 76 хэрэг бүртгэгджээ

Сүүлийн үед мансууруулах бодис худалдах, хил давуулах, хэрэглэхтэй холбоотой гэмт хэрэг ихэссэн. Энэ оны эхний 10 сарын байдлаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 76 хэрэгт 176 хүн холбогдон шалгагдсан тухай цагдаагийн байгууллагаас мэдээллээ. Нийслэл хотод насанд хүрээгүй хүмүүс газ, мансууруулах төрлийн бодис үнэрлэсэн гэх дуудлага мэдээлэл энэ оны эхний 10 сарын байдлаар 30 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 3.4 хувиар өссөн дүнтэй байгаа ажээ. Тиймээс эцэг, эхчүүдэд хүүхдээ энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхийг анхаарууллаа.

"Алтай ятга" маркийн нээлт боллоо

"Монгол шуудан" компаниас "Алтай ятга" сэдэвт цуврал маркийн нээлт өнгөрсөн баасан гарагт боллоо. 2008 онд Ховд аймгийн Манхан сумын Жаргалант хайрханы агуйн булшнаас олдсон эртний нүүдэлчдийн чавхдаст хөгжмийн зэмсгийг манай эриний VII зуун буюу Түрэгний үед хамаарна гэж эрдэмтэд тогтоосон юм. Алтайн ятга хэмээн нэрлэгдсэн 1400 жилийн настай энэ хөгжмийн зэмсгийг хөгжим урлаач П.Байгалжав сэргээн урласан байна. Харин аху их ятгыг хөгжим урлаач Л.Дэмчигтарав урлажээ. Алтай ятгыг маркт мөнхлөх ажлыг "Монгол шуудан" компани, Монгол Уламжлалын академи, "Монгол костюм" төв хамтран гүйцэтгэсэн байна.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

PHOTO NEWS

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга асан Пунцагийн Цагааныг шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн дээд шагнал "Хубилай хаан" алтан медалиар шагналаа. Түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан Олон улсын Монголч эрдэмтдийн XI их хурлыг алжилттай зохион байгуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан, монгол хэл бичиг, соёл, түүх, үндэсний урлагийг судлан шинжлэх, хадгалан хамгаалах, өвлөн уламжлуулах чиглэлд санаачилга, үр бүтээлтэй ажилласныг нь үнэлэн ийнхүү "Хубилай хаан" шагналыг гардуулсан юм.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

NO STRESS

ФОТО УРЛАЧ

Хуучэд насны жаргал...



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -9
Шөнө -19

Нөгөөдөр
Өдөр -4
Шөнө -16

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ЭХЭН
ШАРАГЧИН ГАХАЙ
САР ДӨРВӨН НОГООН
МЭНГЭТЭЙ ЦАГААН
ХУЛГАНА ӨДӨР

Наран ургах шингэх: 07.57-17.16
Үс засуулбал: Өлзийтэй сайн



Тухайн өдөр нохой, хонь жилтнээ амваа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр эл засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал тэтгэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой.

ОДДЫН АМЬДРАЛ

Пинк ХӨЛ ХҮНД болжээ

Б.ДАВАА

АНУ-ын поп дуучин Пинк шүтэн бийрэгчиддээ гэнэтийн бэлэг барилаа. Уран бүтээлийн ажлаасаа хэсэг завсарлага авч, нам гүмхэн байх болсон дуучин бүсгүй саяхан твиттер хуудастаа нэгэн сонирхолтой зургийг нийтэлж, "Гэнэтийн бэлэг" гэх тайлбарыг зүүсэн

байв. Тодруулбал, бүрх малгай өмсч, цагаан өнгийн даашинзаар гоёсон дуучин бүсгүй хөл хүнд зургаа нийтэлж, ёстой л гэнэтийн бэлэг барилаа. Өвөрмөц дуу хоолой, эрч хүчээрээ бусдасаа ялгардаг Пинк 2006 онд мотоспортын тамирчин Кейри Харттай гэрлэсэн. Тэдний том охин 2011 онд мэндэлсэн юм. Тэгвэл хосууд тун удахгүй хоёр дахь үрийнхээ зулайг үнэрлэх гэж байна.

КАНЬЕ УЭСТ Ерөнхийлөгчид нэр дэвших үү


Реалити шоуны од Ким Кардашьяны нөхөр дуучин Канье Уэст 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшинэ гэсэн амлалтаасаа

ухрахаар шийдсэн гэх мэдээлэл шар хэвлэлүүдэд гарч эхэллээ. АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгчөөр Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн Доналд Трамп сонгогдсон. Үл хөдлөх хөрөнгийн магнат гэдгээрээ дэлхий дахинаа танигдсан эл эрхэм нэр дэвшсэн ч Ерөнхийлөгч болно гэхэд олон нийт төдийлөн итгээгүй. Хэвлэл мэдээлэл ч, Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтоньг ялна хэмээн таамаглаж байсан удаатай. Гэвч тэр сонгуульд төлөөлөгчдийн олонхийн саналыг авч, ялалт

байгуулсан юм. Тэгвэл дуучин Канье Уэст ч өнгөрсөн жилийн наймдугаар сард "2020 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр шийдсэн" гэж хэлж байв. Тухайн үед түүний хэлсэн үг бодит байдалд биелнэ гэдэгт итгэх хүн цөөхөн байсан. Гэвч төрд ажилласан туршлагагүй Трамп Ерөнхийлөгч болсны дараа Канье Уэстийг сонгуульд нэр дэвшихийг дэмжигчид нэмэгдэж эхэлсэн байна.

Твиттер сүлжээнд ч "Канье 2020" гэх хаяг трэнд болж эхэлсэн гэнэ. Харин интернэт хэрэглэгчдийн анхаарлыг ийнхүү татсан Канье Уэстийг

Лос-Анжелесийн нисэх онгоцны буудал дээр явж байхад нь "TMZ" сайт "Ерөнхийлөгчид нэр дэвших үү" гэх асуултыг асуужээ. Гэвч дуучин залуу харуулахаас татгалзсан гэнэ. Ямартай ч дээрх асуултад эерэг эсвэл сөрөг аль ч хариултыг өгөөгүй Канье 2020 оны сонгуульд өрсөлдөхийг дэмжигчид сүүлийн үед нэлээд олширсон сурагтай.



ДУУЛГАХ СОНИН

УДЭТ-ын жүжигчин Б.Одончимэг СТА болжээ

"247 градус", "Том толгойтын романс", "Аз жаргалын шок" зэрэг уран сайхны кинонд гол болон туслах дүрийг чадварлаг бүтээсэн нэгэн бол УДЭТ-ын жүжигчин Б.Одончимэг. Тэгвэл залуухан авьяаслаг жүжигчин бүсгүй театрынхаа 85 жилийн ойн баяраар МУСТА цол тэмдгээр энгэрээ мялаажээ. Тэрбээр, "Гэгээ Муза-2011" наадмын "Шилдэг залуу жүжигчин"-ий шагналыг хүртэж байсан удаатай. Ямартай ч хөөрхөн, авьяаслаг уран бүтээлч маань СТА хэмээх цол тэмдгээр энгэрээ мялаалган, шүтэн бийрэгчдээ баярлуулаад авлаа.



Бидэнд тохиолдсон



Selenge Selenge

Би аймаар мартамхай. Машинаа нэг жилийн дотор дөрвөн удаа ачуулж байсан юм. сүүлдээ аймаар айдастай болчихдог юм байна билээ. Жирэмсэн байх үедээ нэг удаа Барс зах ороод юм авчихаад гялс гараад ирсэн машин байдаггүй. Дотор харанхуйлаад л, гомдоод л торгой юм аа хаяад шууд үйлчихсэн. Тэгсэн хүмүүс яасан гээд л ирж байна. Муухай юмнууд машиныг нь ачаад явчихаж. Алив таксинд суулгаад өгье. Энэ тэр гээд л. Би үйлж байснаа гэнэт "Өөө дөвш юм аа. Машингүй ирсэн шүү дээ". Хаха. Тэгээд л зүгээр зүгээр гээд л торгой юмаа аваад гялс явсан даа.

Ундаа Попкорн Үнэгцү

Тасалбараа авааг

ӨДӨР БҮРИЙН ЭХНИЙ ҮЗВЭР МЯГМАР, АХАГВА ГАРИГТ БҮХ КИНО

ТОМ ХҮН	ХҮҮХЭД ХҮН
5,000₮	4,000₮